



“ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 ОН

**“ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ” ХК-ИЙН
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-нд байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхэлсэн. “Ашигт малтмалын тухай” хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

Тавантолгойн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 540 км, хятад-монголын хилээс 270 км-т оршдог, нийт 68,5 мян.га талбайг хамардаг. ЖОРК ангилалд шилжүүлж хийсэн урьдчилсан тооцооллоор 600 метр хүртэл гүнд нийт 7,4 тэрбум тонн нөөц, баялагтай дэлхийн томоохон сайн чанарын коксжих болон эрчим хүчний нүүрсний орд юм.

“Эрдэнэс-Таван толгой” ХК нь: MV-011943, MV-016883, MV-016881, MV-016882, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, тоот бүхий 8 тусгай зөвшөөрлийн талбай эзэмшдэг.

Тавантолгойн орд нь Цанхи, Бортолгой, Бортээг, Оорцог /Баруун өмнөд/, Онч-Хараат /Зүүн/ болон Ухаа худаг гэсэн 6 үндсэн хэсгээс бүрддэг. Цанхийн талбайд нарийвчилсан хайгуул, Бортээг, Оорцогийн талбайд урьдчилсан хайгуул, Ончхараат, Бортолгой талбайд эрэл, үнэлгээний ажил хийгдсэн.

Цанхийн нүүрсний талбай нь коксжих нүүрс агуулсан хамгийн том хэсэг ба ЖОРК ангиллаар нийт 2,9 тэрбум тонн нүүрсний нөөцтэй орд юм.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уулын ажлын талаар


Цанхийн Зүүн болон Баруун уурхайд хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг Ашигт малтмалын газраар батлуулсан төлөвлөгөөний дагуу гэрээт олборлогч компаниудаар гүйцэтгүүлэн, технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны шаардлагын дагуу ажилласан байна.

2016 онд Цанхийн Зүүн уурхайд гэрээт олборлогчоор 7,3 сая тонн нүүрс олборлуулж, 35,4 сая м3 уулын цулын ажил хийж, төлөвлөгөөгөө 2 хувь давуулан биелүүлжээ.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу Цанхийн Баруун уурхайд “Саус Гоби Сэндс Монголиа” ХХК 2016 оны 11 дүгээр сарын 28-наас эхлэн ажиллаж 275 мянган тонн нүүрс олборлож, 875 мянган м3 уулын цулын ажил хийсэн байна.

Нийт хуулсан хөрс, олборлосон нүүрсний хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн болохыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Цанхийн Баруун, Зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт, мян тн /2015-2016 он/



Цанхийн Зүүн болон Баруун уурхайд 4 удаагийн хөндлөнгийн маркшейдерийн хяналтын хэмжилт, зураглал хийлгэж, уулын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна.

Нүүрс борлуулалтын талаар

Тайлангийн хугацаанд Цанхийн Зүүн уурхайгаас 6,33 сая тонн нүүрс борлуулж төлөвлөгөөгөө 17 хувиар давуулан биелүүлсэн байна. Цанхийн Баруун уурхайгаас 1,16 сая тонн нүүрс борлуулж 23,4 хувийн төлөвлөгөөний биелэлттэй байна.


2016 онд нүүрс худалдах 14, нэмэлт 4 гэрээ, нүүрс экспортлох 4, нэмэлт 1 гэрээ тус тус байгуулж, нийт 7,65 сая тонн нүүрс экспортолсон нь 2015 онтой харьцуулахад экспортын хэмжээ өссөн дүнтэй байна.

Монгол Улсын нүүрсний экспортын 32 хувь, БНХАУ-ын нийт коксжих нүүрсний импортын 13 хувь, Гашуун-Сухайт хилийн боомтын нийт экспортын 65 хувийг манай компани дангаараа бүрдүүлж ажилласан.


Цагаанхад дахь “Говь Повер” болон “Алтанговь Транс” гаалийн хяналтын бүс тус бүрт /52,5 мян.тн +137,8 мян.тн / хадгалагдаж байсан Цанхийн Зүүн уурхайн гарал үүсэл бүхий үлдэгдэл нүүрсийг борлуулахаар 3 гэрээ байгуулж, ачилтыг хийлгэжээ. Мөн “Уурхайн нүүрсний овоолгуудад зах зээлийн үнэлгээ хийлгэх” тендер шалгаруулалтын үндсэн дээр Цанхийн Баруун уурхайн агуулахад хадгалагдаж байсан овоолгуудын үнэлгээг зах зээлийн үнэтэй уялдуулан тогтоосноор 1,1 сая тонн коксжих нүүрс, 39,3 мянган тонн исэлдсэн нүүрсийг худалдан авагчдад борлуулсан байна. Нүүрс худалдах ажлын хүрээнд худалдан авагчдын өрсөлдөх тэгш боломжийг

бүрдүүлэх, үр ашигтай, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор нүүрс худалдан авагчийг сонгон шалгаруулахад тавигдах үндсэн шаардлагыг бий болгов. “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн нүүрс борлуулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2015-2016 оны нүүрс борлуулалтын хэмжээг графикаар харуулбал:




“Чалко Трейдинг Хонконг” ХХК-д нийлүүлсэн нүүрсний хэмжээг графикаар харуулбал:



БНХАУ-ын коксжих нүүрсний нийт зах зээлийн үнийг илэрхийлэгч CR China Coking Coal Price Index 2016 оны эхэнд 629.9 пункт байсан бол оны эцэс гэхэд 1460.6-д хүрч, өсөлтийн хэмжээ оны эхнийхээс 2.31 дахин өссөн байна.


CR China Coking Coal Price Index-ийн өсөлтийн графикаар харуулбал



Эх сурвалж: www.sxcoal.com

Компанийн хувьд нүүрсний зах зээлийн тааламжтай үеийг оновчтой ашиглах, нүүрсний үнийг нэмэгдүүлэх, индексийг сайжруулах, борлуулалтын хэмжээгээ өсгөх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч ажилласны үр дүнд Цанхийн зүүн уурхайгаас нийлүүлэх нүүрсний үнийг зах зээлийн өсөлтийн хувьтай дүйцэхүйц хэмжээнд буюу 2.4 дахин (+143%) өсгөж, 24.4 ам.доллараас 59.33 ам.долларт хүргэсэн.

Цанхийн зүүн уурхайн нүүрсний үнийн өсөлтийг графикаар харуулбал




Нүүрсний зах зээлийн үнийн өсөлтийн хамгийн оргил үе нь 4-р улиралд тохиосон. Цанхийн зүүн уурхайн борлуулалтын үнэ улирлаар мөрдөгддөг тул 2017 оны эхний улиралд зах зээлийн үнийн өсөлт биелэлтээ олж мөрдөгдөж байна.

БНХАУ-ын импортын хэмжээ 2016 онд өмнөх жилээс 11.5 сая.тн-оор өсч 59.3 сая.тн-д хүрсэн. Монгол улс БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 40% буюу 23.5 сая.тн-ыг нийлүүлснийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал 13%-иар өсч нийлүүлэлтийн хэмжээг огцом нэмэгдүүлж чадсан байна.

БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 12.6%-ийг манай компани дангаараа нийлүүлсэн ба өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал нийлүүлэлтийн хэмжээ 4%-иар өссөн үзүүлэлт болсон.

БНХАУ-ын коксжих нүүрсний импортод ЭТТ эзлэх хувь:



Эх сурвалж: www.sxcoal.com


Дэд бүтэц, тээвэр, ложистикийн талаар

2016 оны компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан томоохон бүтээн байгуулалтын ажлууд болох гүнийн гаалийн барилга байгууламжуудыг цахилгаанаар хангах 10кВ-ын 1,6 км агаарын шугам, 160кВА чадал бүхий 10кВ-ын дэд өртөө барих төсөл, “Цанхи” хотхоны цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн далан барих ажил нь хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул хэрэгжээгүй байна.


Шинээр барих 18,3 км хүнд даацын хатуу хучилттай авто замын дэвсгэр зургийг боловсруулж, авто замын техник эдийн засгийн үндэслэл болон инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендерийг шалгаруулахад бэлэн болгов.

2016 онд байгуулсан борлуулалтын гэрээний хүрээнд 40 орчим тээврийн компанийн 3054 тээврийн хэрэгсэлд 7,65 сая тонн нүүрс ачиж, экспортлох ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 103593 рейс үйлдэж, нэг хоногт дунджаар 21000 тонн нүүрсийг 309 тээврийн хэрэгслээр ачсан байна.

2015-2016 оны экспортын нүүрсний тээврийг графикаар харуулбал:



Тээвэр гүйцэтгэж буй компаниуд /2015-2016 он/



Нүүрс тээвэрлэлтийн зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 2016 онд нийт 31 тээврийн компанитай нэгж тээврийн хэрэгслийг 3500 төгрөгийн төлбөртэйгээр хучих үйлчилгээ үзүүлэх гэрээтэй ажилласан нь зохих үр дүнтэй болсон байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны талаар

“Эрдэнэс-Таван толгой” ХК нь хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын дагуу осол гэмтэлгүй, хөдөлмөрийн чадвар алдалтгүй 1577 хоног ажилласан байна.

Шинээр хийсэн сургалт

Сургалтад хамрагдсан хүний тоо:	
Шинээр:	1382
Давтан:	449
Жолооны:	298
Сургалтын нийт цаг:	1829,5

Зааварчилгаанд хамрагдсан хүний тоо:	
Зочид:	660
Шинэ ажилтан:	47
Гэрээт компанийн:	881
Өөр ажлын байранд шилжсэн:	19

Шинээр батлагдсан журам

1. ETT-OHS-CP19-A1 - Уурхайн замын хөдөлгөөний журам
2. ETT-OHS-CP08-A1 - Өндөрт аюулгүй ажиллах журам
3. ETT-OHS-CP20-A1 - Хөдөлмөрийн аюулгүй байдлын урамшууллын журам
4. ETT-ADM-CP03-A1 - Хотхоны журам

Шинээр нэвтрүүлсэн маягтууд

1. ETT-MAN-CF07-A1 - 7 хоног тутмын техникийн хяналтын хуудас
2. ETT-OHS-CF27-A1 - Монгол Улсын жолооны үнэмлэх бүртгэх хуудас
3. ETT-OHS-CF28-A1 - Сансрын ИРИДИУМ утас ашигласан тухай бүртгэл
4. ETT-OHS-CF17-A1 - Ажил зогсоосон тухай мэдэгдэл
5. ETT-HYG-CF03-A1 - Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт
6. ETT-HYG-CF04-A1 - Эргономикийн үнэлгээний хяналтын хуудас
7. ETT-MED-CF09-A1 - Анхны тусламжийн иж бүрдэл ашиглах заавар
8. ETT-MAN-CF06-A1 - Техник хүлээлцэх акт
9. ETT-ADM-CF04-A1 - Томилолтын удирдамжийн маягт
10. ETT-OHS-CF29-A1 - Багаж хэрэгсэл хүлээлцэх хуудас

Удирдлага, хяналт шинжилгээний ажлын хүрээнд ажлын байрны үзлэг, ахуйн ус, тоос, газрын доорх ус болон малчдын худгийн хяналт шинжилгээг тус тус төлөвлөгөөний дагуу тогтмол хийж гүйцэтгэсэн.

Эрүүл ахуйн ажлын хүрээнд нийтийн хоолны ажилтнуудад төлөвлөсөн сэдвийн дагуу сургалт явуулж, гал тогооны үндсэн болон шинэ ажиллагсдыг эрүүл зүйн шинжилгээнд хамруулж, хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах нитратын хэмжээг тодорхойлж, хүнсний агуулахад тогтмол ариутгал хийлгэж, гадаргуугийн нянгийн бохирдлыг стандартын дагуу тодорхойлсон байна.

Хурц хордлого, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ашиглаж буй химийн бодисын материалын аюулгүйн мэдээллийн хуудас /MSDS/ хоёроос доошгүйг боловсруулах, хортой ажлын байранд ажиллаж буй ажилтанд хор саармагжуулах болон бусад нэмэлт нэмэгдлүүдийг олгуулах, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /НБХХ/ болон ажлын хувцасны чанар, эдэлгээнд хяналт хийх, ажлын болон амралтын байрны нөхцөлийг сайжруулах, эмнэлгийн гаралтай хог хаягдлын устгал хийх, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх, нийт ажилчдыг эмнэлэгийн үзлэгт хамруулах зэрэг тодорхой ажлуудыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.

Цанхийн Зүүн уурхайн шимт хөрсний 7 дугаар овоолгыг хэлбэршүүлэн засаж, өгөршилд орохоос сэргийлэн олон наст ургамлын үр тариалж, 4 га талбайтай, 50м3-ийн багтаамж бүхий ус нөөцлөх савтай, 700 гаруй бороожуулагч толгойгоор тоноглогдсон уг овоолгод усалгаа, арчилгааг тогтмол хийж ажилласан. Шимт хөрсний

1, 2 дугаар овоолгуудын усалгаа, арчилгааг хаврын улирлаас эхлүүлсэн ба өмнөх жилийн овоолгыг хамгаалах, чанарыг хадгалах ажлыг сайн зохион байгуулсны үр дүнд олон наст болон нутгийн ургамлууд дахин ургасан байна.

Тариалалтад зориулж органик бордоо буюу компост бэлтгэх туршилтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. “1 тонн баялаг-1 мод” хөтөлбөрийн хүрээнд 3500 орчим 7-8 төрлийн суулгацыг цэцэрлэгт хүрээлэн болон нөхөн сэргээлтийн туршилтын талбайд тариалсан бөгөөд ургалтын хувь 80-90 хувьтай байна.

Цогтцэций сумын Сийрст багийн нутаг Хангинах ууланд нутагладаг зэрлэг ан амьтдыг хамгаалахаар 25 цэгт нийт 20 боодол өвсийг тааран байршуулсан. Түүнчлэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу малчдын худгийг тогтмол сэргээж ажилласан болно.

ГУРАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 38 дугаар тогтоол, мөн өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу компанийн газар, хэлтэс, нэгж нь орлогч даргагүй, нэгжүүд болон ажилтнуудын чиг үүргийн давхардалгүй, урсгал зардлыг хэмнэсэн давуу талтай бүтэц зохион байгуулалтыг хийсэн.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу удирдах болон түүнтэй дүйцэхүйц өндөр цалин хөлс авч буй 14 албан тушаалтны орон тоог цомхтгож, гүйцэтгэх захирлын цалинг 50 хувь, дэд захирлын цалинг 30 хувь, газрын захирлын цалинг 5 хувиар тус тус бууруулсан. Мөн цалин хөлсийг тооцож олгох журмын өөрчлөлтөөр хөдөлмөрийн зах зээлээс чадварлаг мэргэшсэн ажилтныг олж авах, ажилтныг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын гүйцэтгэлийг зөв үнэлэх, үр бүтээлтэй ажилласан ажилтны ур чадвар туршлагыг үнэлэх, шударга тогтолцоог бий болгох, албан тушаалын үндсэн цалингийн сүлжээний хэт зөрүүтэй интервалыг ойртуулах, орон нутгийн ажилтныг дэмжих, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, бусад уурхайн цалин хөлсний жишигтэй ойртуулах зэрэг алхмуудыг хийсэн.

Компанийн хэмжээнд үйл ажиллагааны нийт 75 журам мөрдөгдөж байгаагаас 2016 онд 11 журмыг шинэчлэн баталж мөрдүүлсэн нь компанийн дотоод хэм хэмжээ, зохион байгуулалтыг сайжруулах боломжийг бий болгосон байна. Шинэчилсэн журмуудын дотор Компанийн Хөдөлмөрийн дотоод журам багтаж байгаа болно.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захирлын зөвлөл 24 удаа хуралдаж, 91 асуудал хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Нийт 842 албан бичиг хүлээн авч, 2109 албан бичгээр бусад байгууллагатай харилцсан байна. Компанийн ажилчид болон иргэдээс ирүүлсэн 782 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж хариу өгсөн байна.

2016 онд компанийн ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн болно. Нийт сургалтын 73 хувь нь дадлагажуулах, 12 хувь нь мэргэшүүлэх, 11 хувь нь чиглүүлэх, 4 хувь нь хөгжүүлэх чиглэлээр хийгджээ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компани нийгмийн хариуцлагын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Нүүрс тээврийн чиглэлээр төрийн 10, хувийн хэвшлийн 40 гаруй аж ахуйн байгууллагуудтай хамтран ажиллаж, тээвэр ложистикийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн компаниуд болон хил, гааль, авто замын салбарт 2500 орчим ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлсэн байна.
- Цогтцэций сумын хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхэд, “Халуун болор” төвийн тархины саажилттай 60 хүүхдэд тусламж үзүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт компанийн нийт ажилтныг хамруулах зэрэг ажлуудыг амжилттай зохион байгуулав. Түүнчлэн компанийн акталсан хөрөнгөнөөс ЦЕГ-ын сургалтын төвд хэрэгцээтэй эд материалыг шилжүүлэн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн болно.
- “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн уурхайд орон нутгаас ажилчид авах талаар анхаарч ажилласнаар нийт ажилчдын 20 гаруй хувийг Өмнөговь аймгийн иргэд эзэлж байна.

ТАВ. ХУДАЛДАН АВАЛТЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажлыг гүйцэтгэн ажилласан байна.

Хуулийн дагуу тендерийн урилгыг өдөр тутмын сонин, хэвлэлд нийтэлж, тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зар зэрэг материалыг компанийн <https://www.erdenestt.mn/> цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж ил тод нээлттэй ажилласан байна.

2016 онд 504 захиалгыг хүлээн авч холбогдох журмын дагуу худалдан авалтыг хийж, бараа материалыг нийлүүлэх, уурхайд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 506,128,602.90 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
- Харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар нийт 19 худалдан авалтыг зохион байгуулж, 372,772,033 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.
- Нээлттэй буюу зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтаар нийт 5,690,283,000 төгрөгийн худалдан авалт хийжээ.
- Уурхайд зайлшгүй бөгөөд яаралтай шийдвэрлэх шаардлагатай 326 захиалгаар 31,378,525.5 төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

ЗУРГАА. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ТӨСЛҮҮД

- **Хувьцаа**

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмших иргэдийн бүртгэлийг эцэслэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах санал боловсруулан “Эрдэнэс МГЛ” ХХК болон “Төвлөрсөн хадгаламжийн Төв” ХХК-д хүргүүлж, Сангийн сайдын 2016 оны 11 сарын 15-ны өдрийн 379 тоот тушаалаар байгуулагдсан Монгол улсын иргэдийн 1072 ширхэг хувьцааг эдийн засгийн утгаар нь шийдвэрлэх асуудлыг судалж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна. Компанийн балансад иргэдийн хувьцааг бүртгэж, баталгаажуулах зорилгоор хувьцаа эзэмших иргэдийн жагсаалтыг эцэслэх ажлыг тодорхой нэг өдрөөр тасалбар болгох тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гаргуулахаар ажиллаж байна.

Компанийн дүрмийг шинэчлэн батлуулах, тайлан балансад хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг бүртгэж, баталгаажуулах ажлын хэрэгжилтийг хангахад учраад буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд тулгарч ирсэн төрийн мэдлийн хувь хэмжээг тодорхойлох, аж ахуйн нэгжийн мөнгөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай саналыг хүргүүлээд байна.

- **Нүүрс баяжуулах үйлдвэр**

Нэмүү өртөг шингэсэн баяжмал бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор Баяжуулах үйлдвэр барих, усан хангамжийн асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр ажиллаж байна.

- **Компанийн засаглал, нийгмийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр**

Компанийн засаглал, нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилгоор холбогдох Олон улсын стандартуудыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

-----ooOoo-----